

**СҮМЫН ЗДТГ-ТАЙ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН  
ЧИГЛЭЛЭР ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2016 оны 03 сарын 28.-ны одөр

№ 9

Дашичилэн сум

Нэг талаас Булган аймгийн Дашичилэн сумын Нутгийн удирдлага /цаашид “Нутгийн захиргааны байгууллага” гэх/, түүнийг төлөөлж Засаг дарга Д.Луттөмөр, нөгөө талаас “БОЛОР ОРГИЛ МАЙНИНГ” ХХК /цаашид “Компани”/ гэх/, түүнийг төлөөлж захирал Э.Болорхүү /цаашид хамтад нь “Талууд” гэх/ нар Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8., 38.3., 42, 43, 44, дүгээр зүйлүүд, Монгол улсын засаг захиргааны нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нийтийн албанц нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтыг тус тус үндэслэл болгон дор дурьдсан нөхцөлүүдийг хэлэлцэн тохиролцож энэхүү Нийгмийн хариуцлагын гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү гэрээний зорилго нь нэг талаас Булган аймгийн Дашичилэн суманд ашигт малтмалын олборлолтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Компаниас сум орон нутгаас ирүүлсэн саналыг хэрэгжүүлэх, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах хүрээнд сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх нийгмийн хариуцлагыг тодорхойлох, нөгөө талаас Нутгийн захиргааны байгууллага нь Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахад нь хууль, тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахтай холбогdon үүсөх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Талууд хууль дээдлэх, тэгш эрх, шударга ёс, харилцан бие биенээ хүндэтгэх, ил тод байх, сайн дурын үндсэн дээр гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлэх зарчмуудыг баримтлан ажиллана.

1.3. Талууд гэрээг 20.... оны .... сарын ....-ны өдрөөс эхлэн төслийг хэрэгжүүлж дуусах хүртэлх хугацаагаар байгуулав.

**ХОЁР. НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

2.1. Нутгийн захиргааны байгууллага буюу Дашичилэн сумын Засаг дарга энэхүү гэрээний үйл явцад хяналт тавьж ажиллана.

2.2. Нутгийн захиргааны байгууллага нь Компанийг нийгмийн хариуцлагaa хэрэгжүүлэхэд нь хуулийн хүрээнд дэмжлэг туслалцааг үзүүлж хамтран ажиллана.

2.3. Нутгийн захиргааны байгууллагаас энэхүү гэрээний хэрэгжилтийн явц, үр дүнтэй танилцах, хяналт тавих эрхтэй.

2.4. Нутгийн захиргааны байгууллагаас нутгийн малчид, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл, эрх ашиг зөрчигдеж буй эсэхэд Компанийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр хуулийн хүрээнд хяналт тавьж, малчид, иргэдээс компанийн ажилчдын амь нас, эрүүл мэвдэд гэм хор учруулах, гэмт хэрэг, зөрчлоөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.

2.5. Нутгийн захиргааны байгууллага нь гэрээний хугацаанд Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн аливаа үйл ажиллагааг орон нутгийн иргэдэд тухай бүр нь үнэн зөв мэдээлж байна.

2.6. Компанийн шав тэмдэг тавьсан актад үндэслэн компанийн эзэмшилийн тусгай зөвшөөрөлтэй талбайн хил, зааг, малчдын бэлчээрийн хил заагийг хуульд заасан журмын дагуу дахин тодорхойлж компани малчдын хооронд талбайн хил заагийн асуудлыг эв зүйгээр шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлиэ.

2.7. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан хуулиар хориглюсон хүсэлт гаргах, компанийн сайн дурын үндсэн дээр гүйцэтгэх үйл ажиллагааг заавал гүйцэтгүүлэхээр тулган шаардахыг хориглоно.

## ГУРАВ. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

3.1. Компани нь үйл ажиллагаагаа явуулах хүрээнд дараах Нийгмийн хариуцлагыг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлнэ:

### *3.1.1. Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр:*

3.1.1.1. Байгаль орчны хамгаалах тухай хууль, Ашинт малтмалын тухай хууль болон байгаль орчны хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллана.

3.1.1.2. Үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд Байгаль орчинд учирч болох сөрөг нөлооллөөс урьдчилан сэргийлэх;

3.1.1.3. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэй техник, технологийг нэвтрүүлэх;

3.1.1.4. Байгалийн баялгийг зохистой ашиглаж, байгаль орчны нөхөн сэргээлтийг тухайн бүс нутагт нь тохируулан мэргэжлийн түвшинд, технологийн дагуу, стандартын шаардлага хангахуйц хийж гүйцэтгэх замаар хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх;

3.1.1.5. Тухайн жилийн нөхөн сэргээлтийн болон үйл ажиллагааныхаа тайланг сумын БОХ улсын байцаагчид хүргүүлэх;

3.1.1.6. Санхүүгийн тайлан тэнцлээ хуулийн дагуу үнэн зөв гаргаж, татвар хураамжаа хугацаанд нь төлж байна.

3.1.1.7. Захиргааны болон статистик мэдээ судалгааг хугацаанд нь хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв гаргаж өгнө.

3.1.1.8. Ажиллах орчин нөхцлөө сайжруулан тохижуулан.

3.1.1.9. Байгалийн давагдашгүй хүчин зүйл үүссэн нөхцөлд техник, хүн хүчиний болон мэргэжил арга зүйн талаар хамтран ажиллана.

### *3.1.2. Орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшилүүлэх, тогтолцоогийн, тогтвортой, эрүүл, аюулгүй ажлын байраар хангах чиглэлээр*

3.1.2.1. Орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлж, нутгийн иргэдийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтанд хамруулан, дадлагажуулж, туршилагажуулах ажлыг зохион байгуулах;

3.1.2.2. Компани нь уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон, тухайн орон нутгийн иргэдийн аюулгүй байдлыг эн тэргүүнд тавьж, ажиллагсдадаа ямагт сонор сэрэмжтэй байх дадал зурилыг хэвигүүлэн, ажлын байран дахь аюул эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилтантай мэдээлэл солицож, хамтран ажиллах;

3.1.2.3. Аливаа осол аваарыг дахин давтагдахаас урьдчилан сэргийлж шалтгааныг нь тодорхойлон тухай бүр хариу арга хэмжээг авах;

*3.1.3. Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах чиглэлээр*

3.1.3.1. Компанийн ажиллагсдын хоол, хүнс, мах, сүү, цагаан идээ зэрэг хэрэглээний бараа материалыг хангах зорилгоор орон нутгийн иргэд, аж ахуй нэгжээс худалдан авалт хийх замаар орон нутагт хөрөнгө оруулах;

3.1.3.2. Доргонт багийн Гацааны замын шавар шавхайтай хэсгийг хайрган широо асгаж засаж сайжруулах;

3.1.3.3. Дашичилэн суманд нэг ээлжиндээ 4-6 хүнд үйлчлэх нийтийн халуун усны үйлчилгээний байр барих;

3.1.3.4. Доргонт багийн нутаг дэвсгэрт ундны усны худаг гаргах;

3.1.3.5. Багийн төвийг тохижуулах;

3.1.3.6. Сум орон нутгаас зохиогдох урлаг соёл, уралдаан тэмцээн, баяр ёслолын болон байгаль хамгаалах хүмүүнлэгийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцно.

3.1.3.7. Сумын төвийн 0.4 квт болон 10квт-ын эрчим хүчиний шугам сүлжээний хангамжийг тэлж иэмэгдүүлэх асуудлыг зохих мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хамтран шийдвэрлэнэ.

3.1.3.8. Компани нь Нутгийн захиргааны байгууллагыг энэ гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, баримт материалаар хангаж ажиллана.

3.1.3.9. Орон нутаг нь компанийн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөл боломж, холбогдох баримт бичиг зөвшөөрлөөр хангаж ажиллана.

### **3.1.4 Хавсралтаар орон нутагт хийх ажлыг сараар төлөвлөн хавсаргав.**

## **ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ДҮГНЭХ ЖУРАМ**

4.1. Талууд энэ гэрээний биелэлтэнд тавих хяналтыг хамтран хэрэгжүүлнэ.

4.2. Орон нутгийн ойн арга хэмжээ болон орон нутгийг хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын ажлуудыг Талууд харилцан зөвшилицэж, тухай бүрт нь шийдвэрлэн хамтран ажиллана.

4.3. Гэрээний биелэлтийн талаар Талууд энэ гэрээний 1.3-д заасан хугацааны эцэст дүгнэн тайлан гаргана.

4.4. Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад хууль зорчсон аливаа үйлдэл гаргасан тохиолдолд түүний улмаас учирсан хохирлыг буруутай тал нь хариуцаж, Монгол улсад үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

## **ТАВ. БУСАД**

5.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин тоголдор болох ба талууд гэрээний биелсэн гэж үзсэнээр гэрээний үйлчлэл дуусгавар болно.

5.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Гэрээг үйлчлэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

5.3. Талууд энэ гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй ба ийнхүү цуцлахаар бол гэрээг цуцлахаас 3 хоногийн өмнө нөгөө талдаа бичигчид мэдэхүүргэгэй.


5.3. Талууд энэ гэрээг хөдийд ч цуцлах эрхтэй ба ийнхүү цуцлахаар бол гэрээ цуцлахаас З хоногийн омно ногөө таллаа бичигсээр мэдэгдэх үүрэгтэй.

5.4. Энэхүү гэрээний холбогdon гарсан аливаа маргаантай асуудлыг талууд хэлэлцин тохиролцож шийдвэрлэнэ. Хэрэв талууд тохиролцож эс чалвал маргааныг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.


5.5. Гэрээг хоёр хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

НУТГИЙН ЗАХИРГАДНЫ  
БАЙГУУЛЛАГЫГ ГОЛОӨЛЖ:



“БОЛОР ОРГИЛ МАЙННИНГ” ХХК-ИЙГ  
БОЛСО ОРИГИНАЛЫНДАА




ЭХ СУРВАЛЖ: [WWW.ILTODGEREE.MN](http://WWW.ILTODGEREE.MN)

Хавсралт № 1

№	Хийгдэх ажил	Хугацаа
1	Компанийн ажиллагсдын хоол, хүнс, мах, сүү, цагаан идээ зэрэг хэрэглээний бараа материалыг хангах зорилгоор орон нутгийн иргэд, аж ахуй нэгжээс худалдан авалт хийх замаар орон нутагт хөрөнгө оруулах	Төслийн нийт хугацаанд
2	Доргонт багийн Гацааны замын шавар шавхайтай хэсгийг хайрган шороо асгаж засаж сайжруулах	2016.06 сар
3	Дашичилэн суманд нэг ээлжиндээ 4-6 хүнд үйлчлэх нийтийн халуун усны үйлчилгээний байр барих	2016.09 сар
4	Доргонт багийн нутаг дэвсгэрт үндны усны худаг гаргах	2016.06 сар
5	Багийн төвийг тохижуулах	2016.08 сар
6	Сум орон нутгаас зохиогдох урлаг соёл, уралдаан тэмцээн, баяр ёслолын болон байгаль хамгаалах хүмүүнлэгийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцно.	Төслийн нийт хугацаанд
7	Сумын төвийн 0.4 квт болон 10квт-ын эрчим хүчиний шугам сүлжээний хангамжийг тэлж нэмэгдүүлэх асуудлыг зохих мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хамтран шийдвэрлэнэ.	2016.09 сар

ЗӨВШӨӨРСӨН: ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Э.БОЛОРХҮҮ

ЭХ СУРВАЛЖ: [WWW.ILTODGEREE.MN](http://WWW.ILTODGEREE.MN)